



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/60

Улаанбаатар хот

“Улаанбаатар хотын Шуурхай удирдлага,
зохицуулалтын төв ОНӨААТҮГ-ын эргэлтийн
бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 13,473,107.0 /арван гурван сая дөрвөн зуун далан гурван мянга нэг зуун долоон/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨААТҮГ /Ч.Ган-Очир/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 6 нэр төрлийн 13,473,107.0 /арван гурван сая дөрвөн зуун далан гурван мянга нэг зуун долоон/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨААТҮГ /Ч.Ган-Очир/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 03.....дугаар сарын 02-өдрийн 0/60 тоот тушаалын хавсралт



Данснаас хасах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: "Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв" ОНӨААТҮГ

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Хяналтын камер /360гр эргэдэг PTZ CPUNO/	5	Ш	1	2,840,530.0	2,840,530.0	1,967,156.8	873,373.2	цахилгааны гэмтлээс сүлжээний тоног төхөөрөмж шатсан, эх хавтанд байрлах платууд шатсан	Татах
2	Цаг бүртгэлийн төхөөрөмж	4	Ш	1	960,850.0	960,850.0	960,850.0	-	цаг бүртгэлийн нэгтгэлийг алдах, буруу гаргах, нүүр танихаа болих, гацах, шуурхай санах ойн дээрх мэдээллийг хадгалахаа больсон зэрэг системийн доголдол үүсгэж байгаа тул	Татах
3	Дэлгэц /Dell Full HD 2314" Proessional M/	4	Ш	1	462,000.0	462,000.0	462,000.0	-	ашиглалтын хугацаа дууссан, хөндлөн зураас татаж, дүрс гарахгүй болсон.	Татах
4	Утасны аппарат /менежер IP Voptech IP40/	4	Ш	3	561,909.0	1,685,727.0	1,685,727.0	-	байнгын ажиллагааны улмаас адаптар халж шатсан.	Татах

5	Видео ханын дэлгэц /55 инч, хяналтын IP/	4	ш	1	6,645,650.0	6,645,650.0	6,645,650.0	-	байнгын ажиллагааны улмаас дэлгэцэд их хэмжээний халалт өгч сэнс шатаж дэлгэцэд зураас гарч харагдах боломж багассан	Татах
6	Нэвтрэх систем /Access control unit/	4	ш	1	878,350.0	878,350.0	878,350.0	-	ашиглалтын хугацаа дууссан, хуруу мэдрэгчийн линз муудсны улмаас хурууны хээ танихгүй байнга дуут дохио өгч алдаа зааж, хүн танихгүй болсон	Татах
Тоног төхөөрөмжийн дүн				8	12,349,289.0	13,473,107.0	12,599,733.8	873,373.2		
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				8	12,349,289.0	13,473,107.0	12,599,733.8	873,373.2		
Үүнээс: Худалдах хөрөнгө										
Устгах хөрөнгө										
Татан төвлөрүүлэх хөрөнгө						13,473,107.0	12,599,733.8	873,373.2		
Худалдсанаас олох орлого										
НӨАУГ-т төвлөрүүлэх /30%/										